150

ОРХОН АЙМАГ

# ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 18 өдөр Дугаар 02/28 Жаргалант сум

Боловсрол хөтөлбөрийг хэрэгжүүлэх
2026 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит IV хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Боловсрол хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөөг хавсралтаар батлсугай.

2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаан, төлөвлөгөөний биелэлтийг 2026 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнахыг Засаг дарга (Л.Учрал), Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Ө.Батбаяр), 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч (А.Ганцолмон) нарт тус тус даалгасугай.

ДАРГА Ш.БИЛГҮҮНБААТАР

6125010070

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны
12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит IV
хуралдааны 01/18 тогтоолын хавсралт

# БОЛОВСРОЛ ХӨТӨЛБӨРИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.12.10 Жаргалант сум

| № | Хөтөлбөрийн зорилт | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үр дүнгийн үзүүлэлт | | | Санхүүжилт | | Хариуцан хэрэгжүүлэгч |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Суурь он | Суурь түвшин | Зорилтот түвшин (2026 он) | Санхүүжилт сая.төг | Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал | |
| 1 | **Зорилт 1:** Боловсролын байгууллагын багшлах боловсон хүчний мэдлэг боловсрол, заах арга зүйн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх | Багшийг дадлагажуулагч үйл ажиллагааг эрчимжүүлэх. | Дадлагажуулсан багшийн тоо | тоо | 2025 | 30% | Багшлах онол, арга зүйн мэдлэг, чадварыг тогтоож, ахиулахад дэмжлэг үзүүлсэн байна. | Улсын төсөв | Багшийн хөгжлийн зардал | ЕБС |
| 2 | | БС-ын 2025 оны “Журам батлах тухай” А/25 тушаалын хэрэгжилтийг хангах. | Онол, арга зүйн мэдлэг, чадвар дээшилсэн багшийн тоо | Тоо | 2025 | 0% | Багшлах онол, арга зүйн мэдлэг, чадварт дэмжлэг үзүүлсэн байна. | Улсын төсөв | Багшийн хөгжлийн зардал ХПЗ | ЕБС |

153

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | | Багшийн нарын хандлага, ёс зүйн чиглэлээр БМДИ-с багш нарт сургалт явуулах. | Сургалтад хамрагдсан багшийн тоо | Тоо | 2025 | 75% | Мэргэжил арга зүйн туршлага судлах үйл ажиллагаа зохион байгуулж, сургалтад хамрагдсан байна. | Улсын төсөв | Багшийн хөгжлийн зардал ХПЗ | ЕБС |
| 4 | | Багшлах онол, арга зүйн мэдлэг, чадварыг дэмжих. | Сургалтад хамрагдсан багшийн тоо | Тоо /Улирал тутамд/ | 2025 | 0% | Багшлах онол, арга зүйн мэдлэгийг дээшлүүлсэн байна. | 3.5 | ОНХС | ЕБС |
| 5 | | Судлагдахуунд суурилсан хичээлийн судалгаа зохион байгуулж, багшийн арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх. | Түгээн дэлгэрүүлэх арга хэмжээний тоо | Тоо | 2025 | 0% | Багшийн арга туршлагыг түгээн дэлгэрүүлсэн байна. | Улсын төсөв | Багшийн хөгжлийн зардал БХЗ | ЕБС |
| 6 | | Уншаад ойлгох чадвар хөгжүүлэх үйл ажиллагаа болон **“Дэвтэр сурагчийн толь”** аяныг бага ангийн 210 гаруй сурагчдын дунд зохион байгуулах. | Хамрагдсан хүүхдийн тоо | Тоо | 2025 | 60% | Уншсан зүйлээ өөрийн үгээр илэрхийлэх, бүтэн өгүүлбэрээр ярьж сурсан байна. | Улсын төсөв | Бичиг хэргийн зардал | ЕБС |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | | Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор сургуулийн **“Нээлттэй хаалганы өдөрлөг”**-ийг зохион байгуулан ажиллах. | Эцэг эхийн оролцоо (тоо, хувь) | Тоо, хувь | 2025 | 40% | “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулж, суралцагч нарын хичээлд оролцох оролцоог нэмэгдүүлсэн байна. | Улсын төсөв | Бичиг хэргийн зардал | ЕБС |
| 8 | | Эцэг эх, багш ажилтан албан хаагч, суралцагч нарын харилцаа хандлага руу чиглэсэн сургалтыг НТС төвтэй хамтран зохион байгуулах. | Сургалтад хамрагдсан хүний тоо | Тоо | 2025 | 70% | Эцэг эх, суралцагч, багш ажилтан албан хаагч нарын харилцаа хандлагад ахиц гарсан байна. | Улсын төсөв | Бичиг хэргийн зардал | ЕБС |
| 9 | | Цахим орчинд багш өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх, сургалтын арга зүй, туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлэх, цахимаар хичээл заах ур чадвараа сайжруулах, мөн төрөл бүрийн цахим уралдаан, тэмцээнд идэвхтэй оролцох. | Цахим сургалт, цахим санд нэмэгдсэн тоо | тоо | 2025 | 16 | 3 | 1.5 | МТЗ (м эдээлэл техноло гийн зардал) | СӨБ |
| 10 | | “ Багш солилцоо 2026” зохион | Багш солилцоонд | тоо | 2025 | 0 | хүртэлх 2 | - | БАМДЗ (багш, | СӨБ |

154

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулах,хамтын оролцоог нэмэгдүүлэх | оролцох багшийн тоо | | | | | | ажилтны мэргэжил дээшлүүлэх зардал) | |
| 11 | | Салбарын хөгжлийн чиглэлээр багш, ажилтны дунд уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах | Хэлэлцүүлгийн үр дүнгийн хувь | Хэлэлцүүлгийн дүнгийн тоо | 2025 | 0 | 1 | - | БАМДЗ | СӨБ |
| 12 | | "Чадварлаг багш" үзэсгэлэнд өөрийн арга зүй, тэргүүн туршлагаа түгээн дэлгэрүүлэх. | Оролцсон багшийн тоо | тоо | 2025 | 1 | хүртэлх 3 | 1.5 | ОНХС | СӨБ ЗДТГ |
| 13 | **Зорилт 2:** Багш, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах | Эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд нэгдсэн журмаар хамруулах, шаардлагатай тохиолдолд дараагийн шатны эмнэлэгт үзүүлэх. | Үзлэг, оношилгоо зохион байгуулсан тоо | тоо | 2025 | 1 | 2 | - | ЭМЗ (эрүүл мэндийг дэмжих) | ЕБС СӨБ БОЭТ |
| 14 | | Багш ажилтны дунд зонхилж буй өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт тогтмол зохион байгуулах | Сургалт зохион байгуулсан тоо | тоо | 2025 | 1 | 2 | - | ЭМЗ | ЕБС СӨБ |
| 15 | **Зорилт 3:** Багш, ажилтны мэргэжил | Хандлага, ёс зүйн чиглэлээр БМДИ, МБНХ, БҮТ-с мэргэжлийн багш урьж сургалт авах | Сургалтын үр дүнгийн хувь | Хувь | 2025 | 0 | 50% | 1.0 | ОНХС | СӨБ ЗДТГ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаанд олон талт оролцоог хангаж сургалт явуулдаг төр, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх | Багш нарыг үндэсний бичиг, соёлоо эрхэмлэн дээдлэх, сурч эзэмшихэд чиглэсэн сургалтыг НТС төвтэй хамтран зохион байгуулах. | Сургалтад хамрагдсан багшийн тоо | Тоо | 2025 | 0 | 1 | - | БАМДЗ | СӨБ |
| 17 | | Сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх , “Сэтгэл зүйчийн цаг” сургалт, уулзалт | Сургалтад хамрагдсан багшийн тоо | Тоо | 2025 | 0 | 1 | - | БАМДЗ | СӨБ |
| 18 | **Зорилт 4:** Хүүхэд, хөгжил хамгаалал | Хүүхдийг аливаа эрсдэл, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлж“**Хүүхэд хамгааллын хамтарсан баг”**-тай хамтран зохион байгуулах | Зохион байгуулсан ажлын үр дүн, хувиар | Хувь | 2025 | 80% | хүртлэх 90% | - | ХХЗ (хүүхэд хамгааллын зардал) | СӨБ |
| 19 | | Улс, бүс, аймгийн чанартай тэмцээнд оролцуулах | Оролцсон амжилтын хувь | Хувь | 2025 | 65% | хүртэлх 75% | - | ОНТ | ЗДТГ СӨБ |
| 20 | | “Замын хөдөлгөөний-цагаан толгой-2026” тэмцээнд оролцуулах | Тэмцээнд гаргасан амжилтаар | Тэмцээнд оролцсон амжилтаар | 2025 | - | 70% | - | ОНТ | ЗДТГ СӨБ |
| 21 | **Зорилт 5:** Багш ажилтны нийгмийн | Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн гадна | Сургалтад хамрагдсан багшийн тоо | Тоо | 2025 | 0 | 1 | - | ХПЗ (Хичээл практикийн зардал) | СӨБ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | баталгааг хангах, ажиллах нөхцөлийг сайжруулах | сургалтын орчныг бүрдүүлэх арга зүй" модуль сургалт | | | | | | | | |
| 22 | | Байгууллага, хамт олон болон хүн бүрд тогтвортой хөгжлийн талаар мэдээлэл хүргэх, хүн бүрийг идэвхтэй оролцогч болгох ажлыг зохион байгуулах арга туршлагаас суралцах | Ажлын гүйцэтгэлээр | Тоо | 2025 | 0 | 15% | - | БАМДЗ | СӨБ |
| **5 зорилтын хүрээнд 22 арга хэмжээ, Төсөв 7.5** | | | | | | | | | | |

157.